

Чарльз КОРРИ:

«БИД ТӨГС БИЗНЕСИЙН ЗАГВАРЫГ БҮТЭЭДЭГ»

Чарльз Корри Монгол улсад 2016 оны 9 сарын 6-8-ны өдрүүдэд айлчилсан. Энэхүү ярилцлагадаа *BSI* болон *ISO*-ийн техникийн хороодын нарийн бичгийн дарга Чарльз Корри *ISO 9001*, *ISO 14001*, *BS OHSAS*, *ISO 45001* болон *ISO 55001* стандартуудыг боловсруулах ажлыг удирдсан тухай болон стандартууд дэлхийн хөгжилд ямар үүрэг роль гүйцэтгэж байгаа тухай, тэдгээрийн практик давуу талуудын тухай болон эрсдлийн үнэлгээний ач холбогдлын тухай өгүүлсэн юм.

— **Жил бүр бизнесүүд дэлхий нийтийг хамарсан шинэ шинэ асуудлуудтай тулгарч байна: эдийн засгийн хямрал, хэрэглэгч болон зах зээлийн төлөө ширүүн тэмцэл, өрсөлдөөний өсөлт зэрэг. ISO 9001 стандартын 2015 оны шинэ хувилбар байгууллагуудад эдгээр тулгарч байгаа асуудлуудаа шийдвэрлэхэд хэрхэн тус болж чадах вэ?**

— *ISO 9000* бүлгийн стандартууд үүссэн түүхийг эргэн харъя. Анх батлан хамгаалахын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын концепцийг нэвтрүүлсэн нь *BSI*-д энэ төрлийн стандартуудыг бусад салбаруудад бий болгох түлхэц болсон ба 1979 онд Их Британы анхны нийтлэг стандарт *BS 5750 (ISO 9001)* гарч тус орны бүх томоохон компаниуд түүнийг хүлээн авч түүнд тохируулан өөрсдийн үйлдвэрлэлийн тогтолцоог өөрчлөсөн юм. Энэ үйл явдал олон улсын түвшинд анзаарагдахгүй өнгөрөөгүй юм. Британы стандарт дээр тулгуурлан *ISO*-ийн *ISO/TC 176* техникийн хороо нь 1987 оны гурван сард *ISO 9000* серийн стандартуудын төслийг боловсруулж гаргасан.

Чанарын стандартуудыг боловсруулан гаргах болсон шалтгаан нь төрийн байгууллагуудын хяналтаас (хоёр дахь талын аудитаас) “чанарыг хангах” чиглэлд үйлдвэрүүд шилжих шаардлага гарч ирсэнтэй холбоотой юм.

Ингэснээр ханган нийлүүлэгч байгууллагууд гурав дахь талын аудитаар дамжуулан чанарыг хангаснаа баталгаажуулах болсон юм.

Ийнхүү, эдгээр стандартуудыг хэрэглэдэг болсноор компаниуд ханган нийлүүлэгчээ үнэлэхэд зарцуулдаг зардалууд их хэмжээгээр буурсан юм.

Үүнээс хойш *ISO 9001*-д орсон чухал өөрчлөлтүүд эволюцын замаар явагдсан ба стандартын шинэ хувилбарууд цаг хугацааны явцад гарч байсан бизнесийн шаардлагуудыг зохих ёсоор тусгаж байсан.

ISO 9001:2015 оны шинэчлэгдсэн стандартын шинэ зүйлүүдийн нэг бол байгууллагын удирдлагад эрсдэл дээр суурилсан хандлага бий болгосон явдал юм. Дээд удирдлага эрсдлийн үнэлгээ болон магадлалыг ойлгож энэ үнэлгээг байгууллагын стратег

хөгжлийн бизнес төлөвлөгөө гаргахдаа тооцоолох шаардлагатайг ойлгох нь маш чухал болж байна.

— **Таны бодлоор байгууллагыг олон улсын стандартуудад тохируулж баталгаажуулах нь түүний үйл ажиллагааг шинэ түвшинд гаргахад тус болдог уу?**

— Тийм, компанийн баталгаажуулалт нь маш ач тустай процесс юм, гэхдээ зөвхөн тасралтгүй явагдах тохиолдолд. Баталгаажсан байгууллагууд өөрийн баталгаажилтын байгууллагатайгаа хамтын ажиллагаагаа нягтлан “шалгаж” баталгаажилт нь таны байгууллагад нэмүү үнэ цэнийг бүтээхэд тустай хэвээрээ байгааг баталгаажуулж байх хэрэгтэй. Стандартын шинэ хувилбаруудад олон тооны өөрчлөлтүүд орсон, үүний хариуд баталгаажуулалтын байгууллагууд аудитад хандах өөрсдийн хандлагаа өөрчлөх ёстой болж байгаа. Ялангуяа бид эрсдлийн талаар болон түүний байгууллагын хөгжлийн стратеги чиглэлд нөлөөлдөг талаар олж илрүүлсэн өнөөгийн нөхцөлд

баталгаажуулалтын байгууллагууд өөрсдийн үйлчлүүлэгчидтэй харилцахдаа эдгээр хүчин зүйлүүдийг анхааралдаа авах шаардлагатай болно.

Ийм хандлага нь таны бизнесийн үнэ цэнийг үргэлжлүүлэн нэмэгдүүлсээр байх болно.

— **Дэлхий нийт асар их хурдтай өөрчлөгдөж байна, үүнтэй зэрэгцэн технологийн хөгжлийн загварууд ч менежментийн арга барилууд ч өөрчлөгдөж байна. Стандартууд эдгээр өөрчлөлтүүдийг тусгаж амжиж байна уу?**

— Журмын дагуу ISO стандартуудад 5 жил тутамд дүн шинжилгээ хийж тэдгээрийн зохистой байдлыг хангаж байдаг. ISO 9001 ба ISO 14001 стандартуудыг авч үзвэл боловсруулалт ба өөрчлөлт оруулах процесс 7-8 жил үргэлжилж байсан болохыг харж болно.

Энэ нь технологийн хөгжлийн хурдацтай бүрэн дүйцэж байгаа юм. Менежментийн хувьд гэвэл асуу процессд хамаарах ямар ч өөрчлөлт стандартчилж болох юм.

Нэгдсэн Удирдлагын Тогтолцоо (НУТ)-г хэд хэдэн стандарт дээр тулгуурлан загварчилах нь төрөл бүрийн салбар болон үйл ажиллагааны хүрээнд хамгийн сайн үр дүнд хүргэх үйл явцуудыг удирдах боломж олгодог.

Энэ үр дүн нь байгууллагын ажлыг үнэлэх, дотоод ба гадаад харилцааг нэмэгдүүлэх, хэрэглэгч дээр төвлөрөх зэрэгт нэгдсэн хандлагатай болгодог илэрхийлэгддэг.

Стандарт гэдэг нь ЮУ хийх ёстой тухай мэдлэг юм — ЯАЖ хийх тухай биш. Стандартууд нийтлэг зарчмуудыг тогтоогоод зогсохгүй мөн тэдгээрийг хэрэглэдэг ба шаардлагатай үр дүнд хүргэх өөрсдийн алгоритмыг боловсруулж чадах хүмүүсийн саналыг тусгадаг.

Гэхдээ ижил (ө.х. стандартчилагдсан) нэр томъёо, үйл явцуудын журам, эцсийн үр дүн зэрэг нь зөвхөн суурь фундаментийг бүтээж байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй.

НУТ-ыг бүрэн боловсруулах боломжгүй, учир нь ямар ч байгууллагын удирдлагын ямар ч загвар өөрийн онцлогтой байдаг.

— **Менежментийн тогтолцоог хэрхэн илүү үр дүнтэй ба илүү “удирдагддаг” болгох вэ?**

— Удирдлагын тогтолцоо нь таны байгууллага компанийг удирдах хэрэгсэл төдий л юм. Хэр үр дүнтэй байгаа эсэхийг мэдэхийн тулд “Түүнийг ашигласнаар бид ямар үр дүнд хүрэх вэ?” гэдэг асуултыг та өөртөө тавих хэрэгтэй. Тиймээс удирдлагын тогтолцоо нь байгууллагын эрхэм зорилготой нэг байх ёстой.

Тодорхой алхмуудын хувьд гэвэл юуны түрүүнд оновчтой удирдлагыг хэвшүүлэх хэрэгтэй, үүний тулд журам нэг бүрийн үр дүнтэй байгаа эсэхийг дахин дахин шалгаж байвал зохино.

Алхам бүрт, үйл явц болгонд эрсдлийн үнэлгээ хийгдэх ёстой. Үүний тулд мэдээллийг хянах хэрэгтэй: шийдвэр гаргалт нь шалгагдсан баримтууд дээр үндэслэсэн байх учиртай.

Тиймээс өгөгдлүүдийг өөрсдийг нь шинжлээд зогсохгүй тэдгээрийн эх үүсвэрүүдийн найдвартай байдлыг шалах нь чухал юм. Түүнээс гадна, ямар ч байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй байдал зөвхөн бүх сонирхогч талуудынхаа сонирхлыг тооцсоноор хангагдах юм.

— **Таны бодлоор стандартуудын үүрэг роль жилээс жилд хэрхэн өөрчлөгддөг вэ?**

— Анхандаа өндөр, өргөн, талбай зэрэг энгийн хэмжлэлүүдийн үр дүнгүүд стандарт болдог байлаа.

Ингэхдээ, хүний биеийн аль нэг хэсгийн хэмжээсүүд (шууны эсвэл хөлийн улны урт, дунд хуруу чигчий хуруу хоёрын хоорондын зай г.м.) дээр үндэслэсэн хэмжүүрийн тогтолцоо нь Японд дундад зуунд бий болсон боловч 1875 онд л жин хэмжүүрийн эталоны тогтолцоо бий болсон байдаг.

Энэ нь Парижд 17 орны төлөөлөгчид Жин хэмжүүрийн гэрээ буюу метрологийн стандартуудын нэгдсэн байдлыг хангасан олон улсын гэрээ зурагдсаны дараа болсон юм.

Ер нь стандартуудыг нэвтрүүлэх болсон нь олон нийтийн хэрэглэний бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийг явуулахын тулд бэлэн бүтээгдэхүүн болон тэдгээрийн бүрдэл хэсгүүдийг

Персона

хооронд нь харилцан солилцох боломжтой болгох шаардлага гарч ирсэнтэй холбоотой. Жишээ нь ном хэвлэлтийг авч үзье. Хэвлэх машин зохион бүтээснээр ном хэвлэх форматыг тодорхойлсон юм.

Масс үйлдвэрлэл эхэлсэнтэй хамт бүтээгдэхүүнүүдэд болон тэдгээрийн элементүүдэд тавигдах техникийн шаардлагуудыг боловсруулах ажил эхэлсэн.

Тухайлбал, Их Британд 1888 онд гал унтраах анхны загвар тогтолцоонуудыг боловсруулж, 1901 онд стандартын Хороо байгуулагдсан юм; 1903 онд дэлхийн анхны үндэсний стандарт хэвлэгдэн гарсан — энэ нь BS-1 гэдэг ган хийцийн үйлдвэрлэлийн зураг төслийн стандарт байсан ба өнөөг хүртэл хэрэглэгдэж байна; 1931 онд энэ Хороог Британы Стандартын Байгууллага (BSI) болгон өөрчилсөн юм.

Дэлхийн 1-р дайны явцад британы стандартуудыг Далайн цэргийн яам, Худалдааны яам, Ллойддын бүртгэл, Дотоод явдлын яам, автотамын удирдлага, Лондоны тойргийн зөвлөл зэрэг тэр үеийн Британы колониудын засгийн газрууд хэрэглэж байжээ.

1946 онд Олон улсын стандартчилалын байгууллага (ISO) байгуулагдах үед BSI нь иргэний стандартуудаас гадна 400 гаруй онцгой цэргийн стандартуудыг бий болгосон байсан юм. Ийнхүү, бүр анхнаасаа BSI нь ISO-ийн үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсаар ирсэн. ISO-ийн анхны каталогуудад британы 35 мянган стандарт орсон байдаг.

Түүнээс хойш стандартуудын үүрэг роль улам бүр өсөн нэмэгдсэн. 1980-аад онуудын сүүлээр олон улс оронд үйл ажиллагаа явуулж байсан

үйлдвэрлэгчдийн хооронд бараа бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэлтийн технологийн үе шатуудын хуваарилалт бий болсон юм. Энэ нь нэмүү өртөгийн дэлхийн хэлхээг бий болгоход хүргэж үүний үр дүнд эдгээр бүх үйл явцуудын стандартчилал бий болсон юм. Энэ нь олон улсын стандартуудыг идэвхтэй боловсруулан гаргаж хэрэгжүүлж эхлэх үндэс болсон байдаг.

Орчин үед үндэсний ямар ч стандартчилалын тогтолцооны гол зорилго нь — өөрийн орны эдийн засгийн тогтвортой хөгжлийн өндөр хурдцыг хангах үйл явцуудыг ба үйлдвэрлэл үйлчилгээний бүхий л салбаруудын зохистой харьцаатай динамик хөгжлийг дэмжихэд оршдог.

Түүнээс гадна, манай орон үндэсний стандартуудаа олон улсын түвшинд гаргаснаар үнэн хэрэгтээ үндэсний санаануудаа экспортлодог юм. Үүнтэй холбогдуулан хэлэхэд, Их Британы ҮНБ-ний 28,4% нь ямар нэгэн хэлбэрээр стандартчилалтай холбоотой байдаг.

Ийнхүү, стандартууд тухайн орны үйлдвэрлэл ба худалдааны сонирхлыг олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг хангаж шударга өрсөлдөөнийг дэмждэг юм.

Стандартуудын давуу тал нь дэлхий нийтийн хүмүүст найдвартай ба чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ авах өргөн сонголтыг олгодогт байгаа юм. Түүнээс гадна, шинэ үеийн стандартууд хүний бий болгож буй орчины чанарыг тооцож түүнийг тогтвортой байлгах асуудлуудыг шийдэж байгаа нь их чухал юм.

Ингэснээр, стандартууд дэлхийн цаг уурын өөрчлөлтийн асуудлуудыг шийдэх, хүрээлэн буй байгаль орчны хамгаалал ба тогтвортой хөгжлийг хангахад тус болж байна.



Чарльз КОРПИ

Олон улсын стандартын байгууллага (ISO)-ийн техникийн хороодын н/б дарга.

Британы Стандартын байгууллага (BSI) дахь үйл ажиллагаагаа 1993 онд эхэлсэн. BSI-ийн хэд хэдэн техникийн хороог толгойлж байсан.

ISO 9000 серийн стандартуудыг 1994, 2000, 2008 ба 2015 онуудад боловсруулан шинэчилж хянах хороодын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан.

ОHSAS төслийн нарийн бичгийн даргаар үүссэн цагаас нь эхлэн ажиллаж мэргэжлийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн хамгаалалтын удирдлагын тогтолцоонд зориулагдсан ОHSAS 18001 стандартыг боловсруулахад идэвхтэй оролцсон юм.

Одоо BSI-ийн стандартууд боловсруулах албанд удирдлагын тогтолцооны стандартуудыг боловсруулах салбарын шинжээчээр ажиллаж байна.

— **Орчин үеийн стандартууд өмнөх үеийн стандартуудаас өөр юугаар ялгаатай вэ?**

— Гол ялгаа нь зорилго дэвшүүлдэгт байгаа юм.

Гэхдээ биелүүлэх ёстой зорилгыг тодорхойлохын зэрэгцээ стандартууд байгууллагуудад тэдгээр зорилгодоо хүрэх арга замын хувьд хамаагүй илүү эрх чөлөөг олгож байгаа.

Түүнээс гадна, сүүлийн 10 жилд технологи хүчтэй хөгжиж байгаатай холбоотойгоор, хэвлэгдсэн буюу цаасан баримт бичигт тавигдах шаардлага хавьгүй багассан. Бас нэг шинэчлэл бол удирдлагын ойлголтоос манлайлын ойлголтод шилжсэн явдал юм.

Өөрөөр хэлбэл, удирдагчийн хувь хүний үүргийг нэмэгдүүлсэн ба бүх үйл явцад түүний шууд оролцоог онцолсон.

Ойрын ирээдүйд бид нэг нийтлэг, илүү бизнес үйл ажиллагаанд чиглэсэн стандартыг бий болгосноор хэд хэдэн стандартыг нэгдсэн тогтолцоо болгож нэгтгэх шаардлагагүй болно гэж найдаж байна.

— **BSI нь дэлхийн тэргүүлэх компаниудтай хамтран ажилладаг.**

Энэхүү хамтын ажиллагаа та бүхэнд юу авчирдаг вэ? Та бүхэн түнш байгууллагуудынхаа үйл ажиллагаанд хийсэн шинжилгээний үр дүнг салбарын стандартуудыг боловсронгуй болгоход ашигладаг уу?

Үйл

— BSI эхэндээ удирдлагын стандартууд болон арга хэрэгслүүдийг болосвруулах дээр төвлөрөн ажиллаж байсан, энэ нь нэн ялангуяа 1980-аад онуудад Их Британид чанарыг эрхэмлэн хөгжүүлэх үндэсний хөтөлбөрөөр илэрсэн юм.

Өнөөгийн байдлаар бид ISO 9001 стандартын шаардлагууд дээр үндэслэсэн салбарын удирдлагын тогтолцоог боловсруулах ажил дээр анхаарлаа төвлөрүүлж байгаа.

Ийм нөхцөлд, төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын туршлага болон саналыг ашиглаж байна.

Бид юу олж мэдсэн бэ гэвэл, авто машины үйлдвэрлэл, агаар сансарын, телекоммуникацийн гэх мэт томоохон салбаруудын байгууллагуудад ISO 9001-ийн суурь загвар их таалагдаж байсан боловч хэд хэдэн тусгай шаардлагуудыг нэмэлтээр оруулж өгөх шаардлагатай байсан юм.

Тиймээс, ISO 9001 дээр суурилсан ба нэмэлтээр салбарын шаардлагуудыг тусгаж өгсөн хэд хэдэн стандарт бий болсон юм.

Мөн түүнчлэн агаар сансарын аж үйлдвэрийн салбарт үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад тавигдах шаардлагуудыг агуулдаг салбарын удирдлагын тогтолцооны AS 9110 зэрэг олон улсын стандартууд болон телекоммуникацитай холбоотой бүтээгдэхүүний зохион бүтээлт, зураг төсөл, тохиргоо ба үйлчилгээг үзүүлдэг байгууллагуудад тавигдах шаардлагуудын тогтолцоо ба үндсэн зарчмуудыг агуулсан TL 9000 стандартууд үүний тод жишээ юм.

— **Стандартын тохирлын баталгаажуулалт хийлгэх нь чухал гэдгийг бизнесийн байгууллагуудад ялангуяа жижиг дунд бизнесүүдэд хэрхэн ойлгуулах вэ?**

Компани болгонд чанарын алба байдаггүй, гэхдээ байгууллагын удирдлагууд ямар нэгэн зүйл нэвтрүүлэх шаардлагатай гэдгээ ихэнхдээ ухамсарлаж байдаг, ISO гэж зүйл байдагийг ч мэддэг, гэхдээ энэ нь яг юу юм бэ гэдгээ мэдэдгүй шүү дээ.

— Энэ асуултад нилээд нухацтай харуулт өгөх шаардлагатай. Стандарт бол чанарын удирдлагын үндсэн баримт бичигүүдийн нэг.

Түүнгүйгээр төрөл бүрийн тогтолцооны нэгдэл нийцэл ба харилцан солилцоог хэрхэн хангах билээ?

Гагцхүү стандарт л төрөл бүрийн дүрэм журам, зөвлөмж, заавар, үйл ажиллагааны удирдамж зэргийг зөвшилцөлд хүргэдэг баримт бичиг болдог.

Нэг үгээр хэлэхэд, стандарчилал гэдэг нь үйл явцуудыг удирдах арга хэрэгсэл ба энэ нь дэлхийн түвшний хөгжилд хүргэх арга зам юм.

Гэхдээ хэрэглэгдэж байгаа бүх мэдээлэл практик үйл ажиллагааны үр дүн дээр тулгуурлах ёстой юм; тэдгээрт шинжилгээ хийснээр бид “гаралт дээрх” чанарыг хянаж болох ба олон удаа ашиглах дүрэм ба зөвлөмжийг бий болгох боломжтой. Ингэхдээ, стандарт гэдэг нь тодорхойлолт биш, техникийн нөхцөл биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

Стандарт гэдэг нь ЮУ хийгдэх ёстой вэ гэдэг тухай мэдлэг болохоос биш ХЭРХЭН хийх тухай зүйл биш юм.

Стандартууд зөвхөн ерөнхий зарчмуудыг тогтоогоод зогсохгүй, мөн түүнчлэн тэдгээрийг хэрэглэж, хүссэн үр дүндээ хүрэхийн тулд өөрсдийн алгоритмыг боловсруулдаг хүмүүсийн саналыг тусгадаг юм.

Стандартууд зах зээлийн шаардлагууд дээр суурилдаг, тухайлбал, компаниудын үйл ажиллагааны зардлуудыг бууруулахад чиглэгдсэн юм. Үүний үр дүнд, бүтээмж дээшилдэг.

Түүнээс гадна, стандартыг хангаснаар байгууллагын эерэг имиж бүрдэж, найдвартай үйлдвэрлэгч эсвэл ханган нийлүүлэгч гэсэн нэр хүндийг бий болгодог.

— **Та өөрийн ажлын туршлага дээр үндэслэж ажлын болон амьдралын амжилтын нийтлэг томъёог гаргаж чадах уу? Таны хувьд business excellence гэдэг ойлголт нь ямар утгатай вэ?**

— Их сонирхолтой асуулт байна. 1980-аад онуудад эргээд очих юм бол тэр үед Европын чанарын удирдлагын сан (European Foundation for Quality Management) байгуулагдаж чанарын бүрэн удирдлагын (Total Quality Management, TQM) концепцыг боловсруулсаныг санах нь зүйтэй байх.

Энэ концепцээр чанарын хяналтыг ажлын төгсгөлийн үе шатан дээр биш түүхий эд нийлүүлэхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүнийг ачуулах хүртэл бүх замын туршид байгууллагад

Яагаад ISO 9001 “дийлсэн” юм бол?

Энэ стандартад үнэлж хэмжиж болох параметруудад тавигдах шаардлагууд, дараа нь энэ үнэлгээн дээр үндэслэж аудит хийж болох тийм шаардлагууд агуулагддаг юм.

Тиймээс бид чанарын удирдлага буюу бизнесийг бүхэлд нь удирдахад улам боловсронгуй байдалд хүргэхэд тодорхой ач холбогдолтой байж чадах санаануудыг их тодорхой гаргах хэрэгтэй.

Хамгийн мод жишээ гэвэл бидэнд манлайлалтай холбоотой хүн-өдрийн шаардлага байхгүй. Та манлайллыг яаж хэмжих вэ?

Тиймээс манлайлагч юу хийх ёстой, бодлого ба зорилго, харилцаагаа хэрхэн тогтоох зэргийн тухай шаардлагууд орж ирж байгаа юм.

Бид энэ төрлийн санааг тэр бүр бүрэн тодорхойлох боломжгүй, тиймээс ISO 9001 удирдлагын тогтолцоонд байх ёстой үзүүлэлтүүдийн ядаж наад захын зохицуулалтыг бидэнд олгох хэрэгтэй.

Тэгсэн цагт, эдгээр суурь шаардлагуудыг тойроод компаниудад business excellence гэдэг нэр томъёог ойлгох, цаашлаад түүний дагуу хөгжих боломжийг олгох тодорхой санаанууд төрөх юм.

Тиймээс, миний харж байгаагаар, «ISO 9001 стандарт» гэсэн ойлголт нь business excellence гэдэг ойлголттой онцгой тохирч байгаа юм.

ISO 9001-ийг нэвтрүүлсэн компаниуд бүтээмжээ дорвитой сайжруулсан нь их сонирхолтой байсан.

Түүнчлэн, дэлхийн хэмжээнд business excellence тэмдгээр шагнуулдаг компаниуд нь өөрсдийн үндсэн процессууд нь үр дүнтэй ажиллаж байгааг баталгаажуулахын тулд бараг 100% ISO 9001-ийг хэрэглэсэн байдаг. Тиймээс, харилцаа хоёр талдаа байгаа юм.

ISO 9001-ийг хэрэгжүүлэх ажил хийснээр бид төгс бизнесийн загварыг бий болгодог.

Өөрийнхөө бизнесийг бий болгож байгаа эсвэл сайжруулж байгаа хүмүүст бид: **“Та бизнесээ бүр анхнаас нь зөв ба үр дүнтэй авч явъя гэвэл ISO 9001-ийг хэрэглээрэй”** гэж хэлдэг. Тиймээс, энэ нь үнэхээр маш их үр дүнтэй харилцаа юм.



“Business Excellence”
сэтгүүл

Та бүхэн 80308535 утсаар болон undarlaa.battogtokh@bsigroup.com хаягаар холбогдож биднээс сонирхсон асуултаүүддаа хариулт авна уу.